



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ”-ний 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэгт дараах өөрчлөлтүүдийг нэмсүгэй.

4.2.Засаг даргын Тамгын газрын дарга дараах үүрэгтэй

4.2.6.Ажлын байрны дарамт, хүчирхийлэлтэй холбоотой гомдол мэдээллийг шалгах ажлын хэсгийг Тамгын газрын даргын тушаалаар батална. Мөн ажлын байрны дарамт, хүчирхийлэлтэй холбоотой гомдол мэдээлэл төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хамаарах бол байгууллагын Ёс зүйн дэд хороонд шилжүүлж шийдвэрлүүлнэ

4.2.7.Гомдол, мэдээлэлд нэгжийн дарга холбогдож байгаа бол гомдол, мэдээллийг бичгээр Тамгын газрын даргад гаргах бөгөөд Тамгын газрын дарга шийдвэрлүүлэх арга хэмжээ авна

4.2.8.Гомдол, мэдээлэл гаргагчийн талаарх мэдээлэл болон гомдлыг хянах явцад цуглуулсан мэдээллийн нууцыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд зааснаар хадгална

4.5.Албан хаагчид дараах эрхтэй

4.5.5.Хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ёс зүйн зөрчил болон ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн, эсвэл энэхүү нөхцөл байдалд орсон хэн нэгнийг мэдсэн албан хаагч (ажилтан) нэн даруй гомдол, мэдээллийг Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд бичгээр гаргана.

1123000158

4.5.6.Хүлээн авсан гомдол, мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын хамтарсан тушаалаар батлагдсан “Үлгэрчилсэн заавар”-ын дагуу шалгаж, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл бий эсэхийг тогтоож дотоод хяналт хариуцсан албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

4.5.7.Байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны зөвлөлд, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн эс зөвшөөрвөл хуулийн байгууллагад хандана

2.Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т даалгасугай.

ДАРГА  П.САНЖИЙЖАМЦ

